



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/362

Булган сум

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах
өдрийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)
Г.Одончимэг (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
Д.Алтаншагай (Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)
Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга)
Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, хурандаа)
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Ц.Энхтуяа (Булган сумын Соёлын ордны захирал)
Г.Отгонбаяр ("Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" Төрийн өмчит хувьцаат компанийн Булган салбарын захирал)
С.Батнасан (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)
Нарийн бичгийн дарга: Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

2.Тус арга хэмжээг зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

